



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 02 өдөр

Дугаар A/95

Жаргалтхаан

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмших эрхээ шилжүүлэх тухай хүсэлт ирүүлсэн иргэн Эрдэнэчимэгийн Жамсранжав (СМ94060918)-ын хүсэлтийг судлан үзээд, Жаргалтхаан сумын 4-р баг, Зүүн булгийн баруун ам хаягт орших, 2319002527 нэгж талбарын дугаартай, өвөлжөө хаваржааны зориулалттай 10000 квадрат метр газрын эзэмших эрхийг иргэн Янжинлхамын Баатарзул (СМ86040413)-д шилжүүлсүгэй.

2.Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлж, төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэхийг газар эзэмшигчид даалгасугай.

3.Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэхийг сумын газрын даамал (Н.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2018 оны А/104 дугаар захирамжийн хавсралтын холбогдох хэсэг, иргэн Э.Жамсранжавын эзэмшлийн 0000281272 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

Data (D:) /A4 zahiramj/

232401231